



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/438

Чингис хот

Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах тухай" нэгдүгээр хавсралт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.7, 7.12.1, 12.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бусад аймгаас Хэнтий аймгийн нутагт чиглэсэн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хоёр сарын хугацаагаар хязгаарласугай.

2. Отор нүүдлээр бусад аймгаас орж ирсэн 39 өрхийн 25,9 мянган толгой малд мал эмнэлгийн үзлэг, тарилга, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Галшар сум /Б.Энхтайван/, Баянхутаг сум /Д.Байгалмаа/, Дархан сум /Ж.Энхтөр/, Цэнхэрмандал сум /С.Золжаргал/, Дэлгэрхаан сум /О.Анхбат/, Өмнөдэлгэр сум /Б.Эрдэнэбаатар/, Биндэр сум /С.Эрхэмбаяр/, Норовлин сум /П.Алтангэрэл/, Хэрлэн сум /Б.Энх-Эрдэнэ/-ын Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг өндөржүүлэн, малчид, мал бүхий иргэдэд уг захирамжийг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Галшар сум /Б.Энхтайван/, Баянхутаг сум /Д.Байгалмаа/, Дархан сум /Ж.Энхтөр/, Цэнхэрмандал сум /С.Золжаргал/, Дэлгэрхаан сум /О.Анхбат/, Өмнөдэлгэр сум /Б.Эрдэнэбаатар/, Биндэр сум /С.Эрхэмбаяр/, Норовлин сум /П.Алтангэрэл/, Хэрлэн сум /Б.Энх-Эрдэнэ/-ын Засаг дарга, мал эмнэлгийн үзлэг тарилгын ажилд хяналт тавьж дүнг 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ